

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2017 ОНЫ
6 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2017.07.05

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Сэлэнгэ аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчид 06 дугаар сард 2 удаа хуралдаж 10 гаруй асуудал хэлэлцэж 21 тогтоол баталлаа. Үүнд:

-”Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага, хуримтлагдсан өр авлагын барагдуулалт, хэлтсийн үйл ажиллагааны чиг үүрэг, шинээр мөрдөгдөх хууль тогтоомжийн хэрэгжилт болон цаашид авах арга хэмжээний талаарх Эрүүл мэнд нийгмийн даатгалын хэлтсийн даргын мэдээллийг сонсоод Эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг нэмэгдүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

-Хот хөдөөгийн төрийн болон төрийн бус өмчийн сургууль, цэцэрлэг, МСҮТ-үүдийн хооронд тогтвортой түншлэл тогтоох сурагчдыг сургалтын шинэлэг арга зүй, технологид суралцуулах, удирдах ажилтан, багш нарын хамтарч ажиллах боломжийг нэмэгдүүлэх, харилцан туршлага солилцуулах зорилгоор “Багш, сурагч солилцоо” аймгийн хөтөлбөр батлах тухай

-Аймгийн нутаг дэвсгэр дэх байгалийн баялгийг зөв зохистой ашиглах, хуваарилах, хөрөнгө оруулалт татах замаар орон нутгийн эдийн засгийн чадахийг сайжруулах, орон нутгийг хөгжүүлэх санд хуримтлал үүсгэх, шинээр ажлын байр бий болгох зорилго бүхий орон нутгийн өмчийн оролцоотой хамтарсан компани байгуулах тухай аймгийн Засаг даргын санал болон “Сэргээгдэх байгалийн нөөц” ХХК-ийн хүсэлтийг тус тус хэлэлцээд Сэлэнгэ аймгийн нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул, ашиглалтын болон байгаль орчныг нөхөн сэргээх чиглэлээр үйл ажиллагаа эрхлэн явуулах үүрэг бүхий “Сэлэнгэ байгалийн нөөц” ХХК-ийг байгуулах тухай

-Ардын хувьсгалын 96 жилийн ой, аймаг байгуулагдсаны 86 жилийн ойн баяр наадмыг 07 дугаар сарын 10, 11-ний өдрүүдэд тэмдэглэх тухай

-Аймгийн Засаг даргаас оруулсан саналыг хэлэлцээд Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд өөрчлөлт оруулах тухай

-Сум орон нутаг, иргэдээс ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Есүс христийн Эзний улс чуулган” мөн суманд үйл ажиллагаа явуулж байгаа Христийн шашны “Есүс христийн Мөнхийн шинэ чуулган” сүмийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийн хугацааг тус бүр 3 жилийн хугацаагаар сунгаж, Сүхбаатар суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм”, Мандал суманд үйл ажиллагаа явуулж байгаа “Итгэлийн үг” сүмээс ирүүлсэн хүсэлтүүдийг харгалзан “Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүм” гэснийг “Есүс христийн хожмын үеийн гэгээнтнүүдийн сүмийн Сүхбаатар цуглаан” гэж, “Итгэлийн үг” сүм гэснийг “Түнхэл итгэлийн үг” гэж тус тус өөрчлөх тухай

-Боловсролын байгууллагад тасралтгүй 30 гаруй жил идэвх зүтгэл бүр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Дамбажамцын Янжинсүрэнг МУ-ын гавьяат багш цолоор, Хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажилласан Жавхлант сумын ахмад настан Доржийн Агваанбалганыг “Гавьяат агрономич” цолоор, Авто тээврийн салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Сэрчингийн Солийг МУ-ын Гавьяат тээвэрчин цолоор, Эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан зарим

хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 1, Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 15, Цэргийн гавьяаны одонгоор 4, Алтан гадас одонгоор 75, Цэргийн хүндэт медалиар 3, Хөдөлмөрийн хүндэт медалиар 47 хүнийг шагнуулахаар уламжлав.

Мөн 2 дахь хурлаар эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Мандал сумын уяач Дугаржавын Одонгэрэлийг Сэлэнгэ аймгийн Хүндэт тэмдэгээр, Хүнс, хөдөө аж ахуйн салбарт олон жил идэвх зүтгэл үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Ганжууржавын Зоригийг МУ-ын Аж үйлдвэрийн гавьяат ажилтан цолоор, Харилцаа холбоо, шуудан үйлчилгээний салбарт олон жил үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Дуламын Шагдарыг МУ-ын Гавьяат холбоочин цолоор, Боловсролын байгууллагад тасралтгүй олон жил ажиллаж хөдөлмөрийн амжилт гаргасан Сүхбаатар сумын 2 дугаар сургуулийн захирал Содномпилын Энхтайваныг МУ-ын Гавьяат багш цолоор, Сүхбаатар сумын ахмад настан, ахмад багш Бандийн Адьяаг МУ-ын Гавьяат багш цолоор, Эрүүл мэндийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажилласан Мандал сумын ахмад настан Дамбын Баярааг МУ-ын Хүний гавьяат эмч цолоор, шинжлэх ухааны салбарт тасралтгүй 30 гаруй жил ажиллаж эрхэлсэн ажилдаа амжилт гаргасан Сайхан сум дахь Улаанбаатар төмөр замын Төмөр бетон дэрний үйлдвэрийн зөвлөх Сономдоржийн Норжинбадамыг МУ-ын Шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цолоор, боловсрол, эрүүл мэнд, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэлтэй ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 5, Цэргийн гавьяаны одонгоор 4, Алтан гадас одонгоор 51, Цэргийн хүндэт медалиар 4, Хөдөлмөрийн хүндэт медалиар 36 хүнийг тус тус шагнуулахаар уламжлав.

2. Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд нийт 203,0 мянган га-д талбайд тариалалт хийснээс 157,7 мянган га-д үр тариа, 151,1 мянган га-д улаанбуудай, 959 га-д арвай, 2,7 мянган га-д овьёос, 2,8 мянган га-д гурвалжин будаа, 11,0 мянган га-д тэжээлийн ургамал, 34,2 мянган га-д рапс тариалж, уриншийн 1 дүгээр боловсруулалтаар 25500 га-д уринш бэлтгэж байна. Үр тарианы талбайн соёололт 157,7 мянган га талбайн онц нь 19,8 хувь, сайн нь 58,1 хувь, дунд буюу 21,9 хувьтай, муу нь 0,1 хувьтай байна.

Онцгой байдлын талаар:

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

Жил бүрийн 6-р сарын 09-ний “Дэлхийн итгэмжлэлийн өдөр”-ийг тохиолдуулан аймгийн хэмжээнд итгэмжлэгдсэн 9 байгууллага түүний дотор Сүхбаатар суманд үйл ажиллагаа эрхэлж буй 6 аж ахуй нэгж байгууллага, лабораториудын үйл ажиллагааг сурталчлах, “Гурван Мэргэд” зах болон ОУ-ын худалдааны төвийн худалдаа, үйлчилгээ эрхлэгчдэд сурталчилгааны материал тарааж, итгэмжлэгдсэн байгууллага, лабораториудын талаарх мэдээллийг аймгийн цахим хуудаст байршуулсан. Шударга өрсөлдөөн хэрэглэгчийн төлөө газар, аймгийн Хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус зөвлөлөөс хамтран аймаг, сумдад үйл ажиллагаа явуулж буй шатахуун түгээх газруудад хэрэглэгчийн эрхийг хамгаалах талаар заавар, зөвлөмж хүргүүлэхтэй холбогдуулан, Сэлэнгэ аймагт үйл ажиллагаа явуулж буй ШТС-уудын талаарх судалгааг гарган хүргүүлж, СХГ-аас цахим хэлбэрээр зохион байгуулсан “Нөөцлөх савны онооллын хүснэгт зохиох” шалгалт тохируулгын ажилтан бэлтгэх цахим сургалтанд 2 мэргэжилтнийг хамруулсан.

Хууль зүй дотоод хэргийн яам, аймгийн ЗДТГ-ын Хууль, эрх зүйн хэлтсээс хамтран зохион байгуулсан шинээр батлагдсан Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Зөрчил хянан шийдвэрлэх тухай, Прокурорын тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн сургалтанд хэлтсийн 5 мэргэжилтэн оролцож, мэдээлэл авсан.

Аймгийн Засаг даргын Тамгын газар, Ус цаг уур орчны шинжилгээний алба, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Статистикийн хэлтэс, Улсын бүртгэлийн хэлтэс, Стандарт, хэмжил зүйн хэлтэс, Байгаль орчин аялал, жуулчлалын газар, Эрүүл мэнд, нийгмийн даатгалын хэлтэс, Санхүүгийн хяналт-шалгалт, дотоод аудитын хэлтсийн дарга нарын дунд “Цагийн бүсийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийг хэлэлцэх уулзалт ярилцлага зохион байгууллаа. Уулзалтанд оролцогчдын зүгээс Монгол Улсын хэмжээнд нэг цагийн бүстэй байх нь зүйтэй гэж үзэн, тогтоолын төслийг бүрэн дэмжсэн.

“Стандарт, хэмжил зүйн газрын үйл ажиллагааны нэмэлт орлогыг бүрдүүлэх, зардлын хэмнэлтийг бий болгох, түүнийг зарцуулах, хяналт тавих журам”-ын төслийг хамт олны хурлаар хэлэлцүүлж, холбогдох санал боловсруулж холбогдох дээд газарт хүргүүлээд байна.

Зүүнбүрэн, Түшиг, Цагааннуур, Сүхбаатар, Шаамар сум, Дулаанхан тосгоны 17 худалдаа үйлчилгээний газарт холбогдох стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж тохирлын гэрчилгээ олгож, Алтанбулаг сумын нутагт байрлах "Гүннуур" зуслангийн үйл ажиллагаанд "Хүүхдийн зуслангийн үйл ажиллагаа. Ерөнхий шаардлага MNS 5633:2013" стандартын дагуу аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын газар, Эрүүл мэндийн газар, Стандарт, хэмжилзүйн хэлтсийн мэргэжилтнүүдтэй хамтарсан үзлэг шалгалт, тохирлын үнэлгээ хийлээ.

Мөн 4 аж ахуйн нэгжийн 4 нэрийн 4 бүтээгдэхүүнийг сайн дурын баталгаажуулалтанд хамруулан, баталгаажуулалтын шинжээчийн дүгнэлт гаргаж, 1 аж ахуй нэгжийн бүтээгдэхүүнийг тохирлын баталгаажуулалтанд хамруулсан.

Стандартын салбар сангаас 5 аж ахуй нэгж, байгууллага, иргэний 6 нэрийн 6 стандартынзахиалгын дагуу үйлчилгээ үзүүлж, 1 аж ахуй нэгж байгууллага иргэнд 1 нэрийн 1 стандартын борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө өгсөн.

Худалдаа, үйлчилгээ эрхлэгчид болон төрийн байгууллагын 7 ш хэмжих хэрэгслийг шалган баталгаажуулалтад хамруулж, цахилгаанынэг фазын 5ш тоолуурыг шалган баталгаажуулав.

Хоёр.Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

1.Хууль эрх зүй, цагдаа, улсын бүртгэлийн талаар:

2.Архивын талаар

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

2.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

3.Эрүүл мэндийн талаар

4.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

5.Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

Аймгийн Засаг даргын захирамжаар “Хөх сав, канистергүй аймаг, сум, баг, хөдөлгөөн”-ийг аймаг, сум, багийн хэмжээнд өрнүүлж, зориулалтын бус хөх сав, канистерийн хэрэглээ, хор хөнөөлийн талаар зөвлөмж, уриалгыг хэвлүүлэн тараасан.

“Хөгжлийн шийдэл олон улсын байгууллага”-тай хамтран 06 дугаар сарын 18-ны өдөр Сант сумын жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч бизнесменүүдэд “Зээлийн батлан даалтын сангийн тухай сургалт”-ыг зохион байгуулж, сумын 35 бизнес эрхлэгчид оролцож, гарын авлагаар хангаж ажилласан.

Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамнаас 05 дугаар сарын 26-27-нд “Малчдын улсын нэгдсэн зөвлөгөөн-2017” арга хэмжээ Төрийн оронд зохион байгуулагдсан бөгөөд аймгаас нийт 24 малчин оролцсон.Зөвлөгөөнөөр “Мал аж ахуйн салбарын өнөөгийн байдал цаашдын зорилт” илтгэл, “Малчин өрхийн төлөв байдал цаашид анхаарах асуудал” илтгэл, “Малын чанар, үржлийн ажлыг сайжруулах, боломж, мэдээлэл, “Экспортын зориулалттай хурганы мах бэлтгэх боломж” илтгэл, “Малын индексжүүлсэн даатгал”-ын тухай мэдээлэл мөн “Малын генетик нөөцийн тухай хууль”, “Малын эрүүл мэндийн тухай хууль”-ийн төслийн салбар хуралдаан, хэлэлцүүлэгт малчдын төлөөллийг оролцуулсан.

Аймгийн хэмжээнд 1000 бод, 37800 бог малд үзлэг ангилалт хийх тухай аймгийн Засаг даргын 2017 оны 05 сарын 11 өдрийн А/215 тоот захирамжийг боловсруулан батлуулж сумдад хүргүүлэв. Бог малд үзлэг ангилалт хийх ажил орон нутагт үргэлжилж байна. Бод малд 9-р сард үзлэг ангилалт хийнэ. Захирамжийн дагуу Засаг даргын нөөц хөрөнгөөс 6,3 сая төгрөгийг гаргаж 10 сумын 6,8 мян.тол үхэрт үзлэг, ангилалт, ашиг шимийн гарцыг үүлдэр, нас хүйсээр тодорхойлох, цэвэр, эрлийз малын тоог тодорхойлох ажлыг 09 сард багтаан зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

ХХААХҮЯ-ны Малын удмын сангийн үндэсний төв Зүүнбүрэн сумын “Шимт бүрэн” ХХК-ны үржүүлж буй Герефорд үүлдрийн бухнаас 20 мянган тун үр авч Малын удмын сангийн үндэсний төвийн генийн санд хадгалах ажлыг зохион байгууллаа.

Монгол улсын Засгийн газраас 2017 оныг “Мах-Сүүний анхдугаар аян”-ыг зарласантай холбогдуулан малын чанар сайжруулах жилийн ажлын хүрээнд хэрэгжүүлж буй “Эрүүл малд зохиомол хээлтүүлэгийн ажлыг эрчимжүүлэх аян”-ны хүрээнд Зүүнбүрэн суманд 06-р сарын 17-нд Чехийн олон улсын байгууллага, Шимт бүрэн ХХК, Алтантариа ХХК-наас хамтран зохион байгуулж 1 өдрийн сургалтанд сумын ХАА-н тасгийн мал зүйчид хамрагдлаа.

Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ явуулах тухай № А/142 тоот захирамжийн дагуу халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх Боом, Цусан халдварт Сохор догол, Бактерин, Гахайн цусан халдварт иж балнад нийт 47.094 сая төгрөгийн вакцин тарилгыг хүлээн авч хуваарийн дагуу МЭҮН-үүдэд олгосон вакцинжуулалтын ажлыг явуулж байна. Сайхан, Сүхбаатар сумдаас ирсэн өвчилсөн, хорогдсон мал, амьтны 11 эмгэгт дээжинд стандарт арга зүйн дагуу оношлогоо шинжилгээг хийж, УМЭАЦТЛ-иор баталгаажуулан хариуг маягтын дагуу гаргуулан авч холбогдох мал эмнэлгийн нэгж болон иргэдэд өгсөн бөгөөд халдварт өвчний үүсгэгч ирлээгүй. Ийлдэс судлалын шинжилгээнд Сүхбаатар, сумаас 13 адуунд нийлүүлгийн өвчин , ям, адууны халдварт цус багадах өвчний шижилгээ хийж эрүүл болохыг баталгаажуулж хариуг олгосон.

Худалдан борлуулагдаж буй төв нийтийн хоолны газарт нийлүүлэгдэж байгаа мал, аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний Адууны махны 5 дээж, 615 кг, үхрийн махны 55 дээж 6985 кг, хонины махны 110 дээж 2530 кг, сүүний 110 дээж 3300 л, дайвар 1 дээж 30кг, өндөгний 220 дээж 3900 ш дээжинд тус тус МЭАЦ-ийн магадлан шинжилгээг хийж баталгаажуулалж гэрчилгээ олгов.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

1.Хөрөнгө оруулалт, газрын харилцаа, барилга хот байгуулалтын талаар:

Сүхбаатар сумын 6-р сургууль, 7-р цэцэрлэгт өмчийн бүртгэл, эзэмшилт, ашиглалт, хамгаалалт, бүртгэлжүүлэлтэнд хяналт тавьж балансад тусгаж баталгаажуулсан.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжих 504,1 сая төгрөгийн 12 төсөл арга хэмжээ, замын сангийн хөрөнгөөр санхүүжигдэн хэрэгжих 355,5 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын хүрээнд 60 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний тендэрийг тус тус цахим хэлбэрээр зохион байгуулсан. 2017.06.25-ны байдлаар нийт 19 тендер зарласнаас үнэлгээний шатанд 5 төсөл, арга хэмжээ, гэрээ байгуулах шатанд 11, тендер ирүүлэх шатанд 5 төсөл арга хэмжээ, ТББ боловсруулж байгаа 1 төсөл арга хэмжээ байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар эрх нь шилжиж ирсэн Мандал сумын 20 сая төгрөгийн зураг төсөв ирэхгүй хүлээгдэж байгаа ба 50,0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий Сүхбаатар сумын нийтийн тээвэр худалдан авах, ХХААГ-т автомашин авах техникийн тодорхойлолтууд эцэслэгдэн ирээгүй тул тендер зарлагдаагүй байна.

Худалдан авах ажиллагааны сургалтаар мэргэшсэн байгууллагын багш нарыг урьж 2017 оны 06 дугаар сарын 07-ноос 09-ний өдрүүд АЗ сертификат олгох сургалтыг зохион байгуулж, сумдын болон агентлаг, иргэдийн төлөөллийг 65 хамрагдсан бөгөөд үүнээс 60 хүн шалгалтанд тэнцэж АЗ гэрчилгээтэй боллоо.

2017 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэхээр тусгагдсан газраас Сүхбаатар, Алтанбулаг, Баянгол сумдад газрын цахим биржээр 9 газрын 65992 м2 газрын дуудлага худалдааны зарыг байршуулсанаас Сүхбаатар суманд худалдаа үйлчилгээний зориулалттай 1 нэгж талбарын 92м2 газрыг 1020,0 мянган төгрөгөөр, Алтанбулаг суманд худалдаа үйлчилгээний зориулалттай 1 нэгж талбарын 400м2 газрыг 534000 мянган төгрөгөөр, Баянгол суманд танхимаар худалдаа үйлчилгээ ШТС-ын зориулалттай 1 нэгж талбарын 10000 м2 газрыг 8122,6 сая төгрөгөөр, тус тус худалдаж эзэмшүүлсэн.

2.Байгаль орчны талаар:

Ойн судалгаа хөгжлийн төвийн ажлын хэсгийн хамт Баруунбүрэн, Сант, Алтанбулаг, Цагааннуур, Хүдэр, Ерөө/ Бугант/ сумын ойн санг гэрээгээр эзэмшигч 38 нөхөрлөлүүдийн төлөөлөгч нартаа уулзалт зохион байгуулсан. FAO төслийн багтай хамтран Цагааннуур сумын Харгистай баян бүрд, Нүхт агуйт, Алтанбулаг сумын Хишиг-Өндөр, Баруунбүрэн сумын Бүрэнтоонч, Бумбат хангай, Байгалийн хишиг, нөхөрлөлүүдэд түвшин тогтоох үнэлгээг хийлээ.

“Олон улсын цөлжилттэй тэмцэх өдөр”-ийг сум орон нутагт хэрхэн зохион байгуулах талаар сумын Засаг дарга нарт албан тоот хүргүүлэн, мэргэжил арга зүйн зөвлөмж өгч, уг өдрөөр хийсэн ажлын тайланг нэгтгэв.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар гүйцэтгэж буй ойн хөнөөлт шавжийнтэмцлийн ажлыг Баруунбүрэн суманд 8000 га талбайд, Сант сумын 4000 га талбайд “ОХСТ” ХХК тендерт шалгарч гүйцэтгэсэн.

Цаг уурын хэт халалт, хуурайшилтын улмаас Баруунбүрэн, Сант зэрэг сумдад ойн хөнөөлт шавжийн тархалт, олшрол хэт их болж ойн сангийн талбайд үлэмж хэмжээний хохирол учруулж байна. Иймд хөнөөлт шавжийн хэт олшролттой Сант,

Баруунбүрэн, Цагааннуур зэрэг сумын ойн сангийн талбайд тэмцлийн ажлыг 9000 гаруй га талбайд онгоцоор тэмцлийн ажил явуулах дэмжлэг авахаар болоод байна.

Долоо.Сум орон нутгийн талаар:

Зүүнбүрэн сум:

2017 оны Ерөнхийлөгчийг сонгох ээлжит сонгуультай холбогдуулан 844,845 дугаар хэсгийн ахлах зохион байгуулагч, зохион байгуулагч нарт Зүүнбүрэн сумын сонгуулийн хорооноос “Сонгуулийн тухай” хуулиар сургалт зохион байгуулж, чиглэл өгч зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар нь Зүүнбүрэн сумын “Алтан тариа” ХХК, “Шимт бүрэн” ХХК, Чех улсын генетикийн “Natural” ХХК-тай хамтран “Үхрийн хээлтүүлэг болон хээлтүүлгийн мал сонгох” дадлагажуулах сургалтыг 06 дугаар сарын 17-ний өдөр Зүүнбүрэн суманд зохион байгууллаа. Сургалтанд сумдын хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч, сумдын малчдын төлөөлөл хамтран зохион байгуулсан аж ахуйн нэгжүүдийн мэргэжилтэн, ажилчид нийт 40 гаруй хүн оролцож Зүүнбүрэн сумын “Шимт бүрэн” ХХК-ний үржүүлж буй Герефорд үүлдрийн үхрийн аж ахуйтай газар дээр нь танилцаж үр дүнтэй болж, фермчдийг малын удмын сангаа сонгож, зохиомол хээлтүүлгийн аргыг үр дүнтэй хэрэглэх фермд хээлтүүлгийн үхэр сонгох, үзүүлэлтүүдээр тестлэх болон зөв генийн сонголтыг орчин үеийн тоног төхөөрөмж ашиглан хийхийн давуу талуудыг танилцуулан хээлтүүлгийн төлөвлөгөөг зөв ашигласнаар үхрийн үүлдрээ сайжруулах, үнээний ороог гормоноор идвэхжүүлэх, сүүний чиглэлийн үржлийн үхэр сонгох талаар үндсэн ойлголт, махны чиглэлийн үржлийн үхэр сонгон шалгаруулалт хийх талаар үндсэн ойлголт, хээлтүүлгийн төлөвлөгөө, үнээний ороог гормоноор өдөөлт хийх тухай, хээлтүүлгийн үрийн шингэний чанар болон хэмжээ, хэрхэн зөв хадгалах, хэрэглэх талаар мэдлэгийг олголоо.

Хүүхдийг эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 14 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Аав ээж би”, 4-5 насны хүүхдүүдийн дунд гүйлт, 7-8 насны хүүхдүүдийн дунд “Аав бид -2 ” тэмцээн, 8-12 дугар ангийн сурагчдын дунд Хүүхэд гэр бүлдээ жаргалтай гар зургийн уралдааныг тус тус зохион байгуулж тэргүүн байр эзэлсэн хүүхдүүдийг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, гарын бэлэгээр шагнаж урамшууллаа.

“Алтан тариа” ХХК нь хамгийн олон ном уншсан 10 сурагч, амжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 5 өрхийн 5 хүүхдэд тус тус гарын бэлэг гардуулж, баярын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад таргаар үйлчиллээ.

4 ба түүнээс дээш олон хүүхэд төрүүлж өсгөсөн 10 эхийг алдарт эхийн 1,2 дугаар одонгоор шагнах ёслолын арга хэмжээг зохион байгуулж ажиллалаа.

Ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1, бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах эргэн буцалтгүй төсөл хөтөлбөрт-6 иргэнийг тус тус хамруулж 6 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг үзүүллээ.

06 дугаар сарын байдлаар ажилгүйдлийн бүртгэлд 15, шинэ ажлын байранд 17 иргэн бүртгэгдээд байна. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжүүлж буй талбай засах, тохижуулах нийтийг хамарсан ажлыг эхлүүлж 15 иргэнийг түр ажлын байраар ханган 4,200,000 төгрөгийг зардал гаргалаа.

Халдварт өвчнөөс сэргийлэх био тарилга, туулгалтанд мал сүргээ бүрэн хамруулах талаарх ухуулга сурталчилгааг малчин, мал бүхий 210 гаруй өрхөд хүргэж, мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх дархлаажуулах ажлыг мал эмнэлгийн үлгэрчилсэн графикийн дагуу хэрэгжүүлснээр гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд 10700 толгой мал хамруулж 31 хувьтай явагдаж байна.

2017 онд 15 аж ахуйн нэгж, 6 иргэн нийт 13201 га талбайд тариалалт хийсэн ба төрлөөр ангилвал улаан буудай 9061 га, гурвалжин будаа 40 га, арвай 405 га,

овьёос 102 га, ногоон тэжээл 180 га, эрдэнэшиш 35 га, шар буурцаг 308 га, рапс 3050 га, гүнжидийн үр 20 га талбайд тус тус тариалалт хийж төлөвлөгөөгөө 101,4%-иар давуулан биелүүллээ. Төмс, хүнсний ногооны хувьд 3 аж ахуйн нэгж, 198 иргэн 35,6 га-д төмс, 274,43 га-д хүнсний ногоо тариалж төлөвлөгөөгөө 79,4 % биелүүлж ажиллалаа.

Баруунбүрэн сум:

Сумын хэмжээнд 20 аж ахуй нэгж, 14 иргэн 11023 га талбайд улаан буудай, 10 га талбайд арвай, 10 га талбайд гурвалжин будаа, сүүт азаргана 100 га, хунчир 5 га, дэрвэгэр жиргэрүү 40 га, тэжээлийн ургамал 80 га, маалинг 80 га, рапс 1371 га талбайд тус тус тариалаад байна.

Төмс, хүнсний ногооны хувьд 95 га талбайд төмс, 77 га талбайд хүнсний ногоо тариалаад байна. Сумын хэмжээнд ажлын хэсэг байгуулан улаан буудай тариалсан аж ахуй нэгж, иргэдийн талбай бүрээр явж соёололтын үзлэгийг явуулахад нийт талбайн соёололт жигд сайн зарим аж ахуй нэгжийн талбай хогтолттой байсныг тухай бүрт нь зөвлөгөө өгч ажиллаа.

ИТХ-аар батлагдсан чиглэлийн дагуу сум хөгжүүлэх сангийн зээлд хамрагдах иргэдийн төслийг хүлээн аваад байна.

Аймгийн үндэсний статистикийн газарт сар бүрийн эцэст том малын хорогдол, мал төллөлтийн мэдээг гарган хүргүүлж байсан бөгөөд одоогийн байдлаар сумын хэмжээнд нийт 80089 толгой хээлтэгч мал төллөхөөс 50745 толгой хээлтэгч төллөж, 50745 толгой төл гарснаас 1145 толгой төл хорогдож, 49600 толгой төл бойжиж байна.

Аймгийн Засаг даргын 2017 оны 5-р сарын 11-ний өдрийн А/125 тоот захирамжийг үндэслэн сумын Засаг даргын 2017 оны 5-р сарын 22-ны өдрийн А/168 тоот захирамжийн хэрэгжилтийг ханган мал ангилалт, ашиг шимийн судалгаа хийх ажлын хүрээнд ангилалтанд нийт 7000 бог мал хамрагдаж бог малын ангилалтын тайланг аймгийн ХХААГ-т хүргүүлсэн. Мөн оны эхэнд бог малын хээлтүүлэгчийг хээлтүүлгийн бус хугацаанд нь 5 өрхөд ялган суурилж ангилалт үзлэгт хамруулан жишигт тэнцсэн 560 хуц, 385 ухныг хээлтүүлэгт ашиглана.

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 113 тоот тогтоол, Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 06-ны А/142 тоот, Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын Засаг даргын 2017 оны 04 дүгээр сарын 07-ны А/39 тоот захирамжийг тус тус үндэслэн Мал эмнэлэг, эрүүл ахуй, халдваргүйжүүлэлтийн сарын аяны хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулан хийж гүйцэтгэсэн. Үүнд:

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилганд шөвөг яр өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг ишиг-7300, мялзан өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг гахай-100, галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг бод-1200, доторын халдварт хордлого өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг /давтан/ бог-5200, дуут өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг бод-6400, цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакциныг хонь-34800, хурга-33800 /давтан/, бүгд-88800 толгой мал амьтанд, паразиттах өвчнөөс эмчилэн сэргийлэх гуурын боловсруулалтанд бод-2100, бог-23000, цагаан хорхойн туулганд бод-165, бог-28000, нохой-220, бүгд-53485 толгой мал амьтадыг тус тус хамруулсан.

Төрийн санд 2017 оны эхний хагас жилийн байдлаар орон нутгийн төсвийн орлогод 60461.5 төгрөг төвлөрүүлэхээс 40092.3 мянган төгрөгийг төвлөрүүлж, биелэлт 66.3%-ийн биелэлттэй байна.

Тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт төлөвлөгөөгөөр 761967.8 мянган төгрөг ирэхээс 761967.8 мянган төгрөг ирж гүйцэтгэл нь 100% санхүүжигдсэн. Зардлын гүйцэтгэл нь 685771.0 мянган төгрөг байна.

Мал эмнэлэгийн үйлчилгээний санхүүжилт 11448.0 мянган төгрөг ирснийг 7230.3 мянган төгрөгийн зардлыг олгосон бөгөөд, үлдэгдэл санхүүжилтийг вакцинжуулалтаа хийж дууссаны дараа авна.

Орон нутгийн болон ТЗШ-ийн байгууллагуудын 11446.5 мянган төгрөгийн авлагатай, 20053.1 мянган төгрөгийн өглөгтэй байна. Сум хөгжүүлэх сангийн хүүгийн авлага 10526.0 мянган төгрөг, зээлийн авлага 149008.0 мянган төгрөг, нийт 159534.0 мянган төгрөг байна.

Сумын эрүүл мэндийн төвөөс Артерийн гипертензийн эрт илрүүлийн үзлэг -20, чихрийн шижингийн эрт илрүүлгийн үзлэгт-25 хүнийг, Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд сумын 40-65 насны иргэдийн судалгааг шинэчилэн гаргаж, аймгийн ЭМГ-аас 560 хүнийг элэгний В,С вирусийн шинжилгээнд хамруулж байна.

Сумын ойн санд тархсан хөнөөлт шавжтай хийх тэмцлийн ажлыг гүйцэтгэгч “ОХСТ” ХХК-аас гаргасан хүсэлтийн дагуу тэмцлийн ажил явуулах тухай сумын Засаг даргын захирамжийг гаргуулан, хэрэгжилтэнд нь хяналт тавин ажиллаа. Гэрээнд заасан 5000 га талбайд тэмцлийн ажлыг хийсэн боловч хортон тархалт их болсон талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулсаны үндсэн дээр нэмэлтээр 3000 га талбайн ажил авч сумын дүнгээр нийт 8000 га талбайд тэмцлийн ажил хийгдээд байна.

Жирэмсний хяналтанд-44 эх байгаагаас тайлант сард шинээр 5 жирэмсэн эхийг хяналтанд хамруулж, эхний болон давтан шинжилгээнд бүрэн хамруулах арга хэмжээ авсан.

Монгол Улсын Засгийн газрын 2009 оны 185 дугаар тогтоолын дагуу заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлолын дагуу 0-2 насны 75 хүүхдийг товлолын вакцинд хамруулснаас гадна 6 сартай хүүхдүүдийн судалгааг сар бүр гаргаж Улаанбуруханы вакциныг хийж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй 0-16 насны 6 хүүхдийг аймгийн нэгдсэн эмнэлгийн салбар хороонд асаргаа сунгах зөвлөгөөнд оруулсан.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэг нээлтэй хаалганы өдөрлөг зохион байгуулж дотор, хүүхэд, эмэгтэйчүүд, мэдрэл, сэтгэц, мэс засал, шүд, нүд, ЭХО, ЭКГ-ийн үзлэг шинжилгээнд давхардсан тоогоор нийт 358 иргэдийг хамруулав.

Тайлант сард сумын авьяаслаг сурагчдын “Бид цэцэрлэгийн багачууд” тайлан тоглолт, “Урлаг-Спорт 2017” аяны хаалтын тоглолт, үдшийн цэнгүүн, Амарбаясгалант хийдэд Далхбүрэн уулын овоо тахилгын баяр наадмын урлагийн арга хэмжээ болон Дэлгэр өндрийн овоо тахилгын наадам, Цагаан овоо, Зайсан, Өгөөмрийн овоо тахилгын арга хэмжээг хамтран зохион байгуулж, “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор эх үрсийн баярын арга хэмжээг зохион байгуулж Алдарт эхийн одон гардуулах ёслол, Дархан бэр алдаршуулах ёслолын арга хэмжээ, ЕБС-ийн сурагчдын тайлан тоглолт зохион явуулсан.

Жавхлант сүм:

“Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” сэдвийн дор эх үрсийн баярыг зохион байгуулж “дэлхий дүүрэн бага нас” урлагийн тоглолт, “Ээжтэй орчлон” үдшийн цэнгүүнийг зохион байгуулж байгууллага, ААНэгж, ТББ, иргэдээс нийт 85 хүүхдэд гарын бэлэг гардууллаа. Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн 116 дугаар зарлигаар алдарт эхийн одонгоор 8 ээж шагнагдаж энгэрээ мялаалаа.

УИХурлын гишүүн Н. Оюундарь орон нутагт ирж ажиллан эрүүл мэндийн төвд хүчилтөрөгчийн өтгөрүүлэг 1 ширхэг, суурийн компьютер 1 ширхэг, 26-р цэцэрлэгт шарах шүүгээ 1 ширхэг, дээж хадгалдаг хөргөгч 1 ширхэгийг хүлээлгэн өглөө.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ээлжит сонгуулуулийн 843 дугаар санал авах үйл ажиллагаа амжилттай болж сонгогчийн нэрсийн жагсаалтад 132 сонгогч бүртгэгдсэнээс 66,82 хувь буюу 900 сонгогч саналаа өгч М. Энхболд 38,12 хувь буюу 343 санал, С. Ганбаатар 34,67 хувь буюу 312 санал, Х. Баттулга 26,12 хувь буюу 235 саналыг тус тус авлаа.

Ахмад настны эрүүл мэндийг хамгаалах үүднээс Сүхбаатар сумын ахмадын сувилалд 20 ахмад настанг амрууллаа. Энэ сард шинэ төрсөн -6, эцэг тогтоох бүртгэл -4, гэрлэлтээ бүртгүүлсэн-3, иргэний үнэмлэхний олголт -14, үндэсний энгийн гадаад паспорт шинээр захиалах, хугацаа сунгалт хийлгэсэн -3, шинээр цахим үнэмлэх захиалсан 8 иргэн нийт 38 иргэний бүртгэл хийгдлээ.

Аймгийн нэгдсэн эмнэлэгийн 17 хүний бүрэлдэхүүнтэй явуулын амбулаторын баг эрүүл мэндийн төвд ажиллан 338 иргэнд үзлэг шинжилгээ, оношилгоо хийлээ.

Сумын 40 жил болохтой холбогдуулан 40 жилийн ойн концертын бэлтгэл ажил эхэлж бүжиг анги, дууны анги, ятгын дугуйлан, морин хуурын дугуйлангууд ажиллаж байна.

Аймгийн 139,1 сая төгрөгөөр хийгдэх 4 ажил, сумын орон нутаг хөгжлийн сангаар хийгдэх 1 ажлын тендер зарлагдаж ажил эхлээд байна. Үүнд: 29076,0 мнган төгрөгөөр Соёлын төвийн хөгжим техник хэрэгсэл худалдан авах ажил, 80,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэх “Цэнгэлдэх хүрээлэн” барих ажил, 10,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэх морь барианы ажил, аймгийн замын сангийн 10,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар хийгдэх “Зам засах, тэмдэг тэмдэглэгээний ажил, сумын орон нутаг хөгжлийн сангийн 37,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх “ Үерийн усны суваг шуудуу засах” ажлуудын гэрээ хийгдэн ажил хэрэгжих шатандаа явж байна.

2017 онд 22 аж ахуйн нэгж байгууллага, 50 иргэний нийт 10186 га талбайд тариалалт хийгдсэнээс 7590 га-д улаан буудай, 400 га-д гурвалжин будаа, 15 га-д ахрвай, 106 га-д тэжээлийн наранцэцэг, 116 га-дд чонын өргөс, 5 га-д шар буурцаг, 11 га-д эрдэнэ шиш, 1950 га-д рапс, 61 га-д төмс, 87 га-д хүнсний ногооны тариалалт хийгдээд байна.

Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг үр тарианы соёололтын үзлэгийг хийж дуусгалаа. Үүнд: 15 аж ахуйн нэгж, 2 иргэний нийт 7590 га улаан буудай тариалсан талбай хамрагдсан ба соёололтын үзлэг йн дүнгээр 85 % нь соёололт жигд хогтолот бага, сайн үнэлгээ авсан байна.

Тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгжүүд тариагаа хашаажуулах ажлыг зохион байгуулж байгаа бөгөөд “Хурниад” ХХК 832 га талбайд 12 км, “Жавхлант буудай” ХХК 282 га талбайд 7 км, “Бадрал Оргил” ХХК 110 га талбайд 10 км, “Ачит Оргил” ХХК 291 га талбайд 1,4 км, “Газар өгөөж” ХХК 750 га талбай, “Өгөөмөр Хантайж” ХХК 2165 га талбайд 42 км-г тус тус хашаажуулаад байна.

Төвийн болон хөдөөгийн зам дагуух хог хаягдал цэвэрлэх ажлыг аймгийн хөдөлмөр халамжийн үйлчилгээний газартай хамтран зохион байгуулж сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбайг, элстэй хөтөл, Хөх хошуу, Зураа тохой, Шарын гол, Хүйтнийгол, Ерөө голын гүүрний ойр орчмыг цэвэрлэх ажлыг зохион байгууллаа.

Аймгийн хөдөлмөр халамж үйлчилгээний газар, “ЭЙ, БИ АЙ, СИ”, хөгжлийн хөтөч, ОУЗ ТББ-тай хамтран зорилтот өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд Төсөл гэж юу вэ, төслийн баримт бичиг, ажил мэргэжлийн талаарх ойлголт харилцааны соёл зэрэг 3 хоногийн сургалтыг зохион байгуулж 40 иргэнийг, 2017 онд хэрэгжих бүлгийн зохион байгуулалттайгаар хүнсний ногоо тариалах сургалтанд иргэдийг хамруулан сумын төвийн зорилтот 15 өрхийн дунд сургалт зохион байгууллаа.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР